

2020. 1d. 15-ийн оюутаны салбарын  
худалдаагаа албан шаардлагадаа  
төсөвийн оюутаны  
оршижээ.

Дундхорол  
Б.Бундхорол

БАТЛАВ.  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.БУНДХОРОЛ

## АЖЛЫН ДААЛГАВАР

### Нэг. Ерөнхий зүйл

#### 1.1 Хэрэгцээ шаардлага:

Төрийн аудитын бодлого, арга зүйг олон улсын жишиг, стандартад нийцүүлэн аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн олон зорилтод арга хэмжээг Төрийн аудитын байгууллагаас төлөвлөн хэрэгжүүлж байна.

Аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийг арилгах шийдвэр шалгагдагч байгууллага болон хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, баримт нотолгоонд тулгуурласан, бодитой бөгөөд хэрэгжүүлэх боломжтой, үр өгөөжтэй байх ёстой.

Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, дээрх шаардлагад нийцэж байгаа эсэхийг судалж, нөхцөл байдлыг үнэн бодитой тодорхойлж, энэ чиглэлээр баримтлах бодлого, арга зүйг боловсронгуй болгох, хөгжүүлэх нь тулгамдсан асуудал юм.

#### 1.2 Зорилго, ач холбогдол

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны гол үр дүн болох аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийх мэдээллийн санг загварчлан, өмнөх өгөгдөл мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим систем боловсруулж, хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Төрийн аудитын байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд энэхүү зөвлөх үйлчилгээ чухал нөлөөтэй юм.

#### 1.3 Ач холбогдол

Төрийн аудитын үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн шийдлүүдийн хэрэгжилт, үр дүнг тооцох, тэдгээрийн чанар үр нөлөө, үр өгөөж ямар байгааг мэргэжлийн түвшинд судалж, нөхцөл байдлыг хараат бусаар бодитой тодорхойлох боломж бүрдэнэ.

Ингэснээр цаашдын бодлого, зорилтоо оновчтой тодорхойлох, хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, аудитын чанар үр нөлөө, дээшлэх боломж нэмэгдэх юм.

## **1.4 Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ**

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2018, 2019, 2020 оны төлбөрийн акт, албан шаардлагыг цуглуулж, мэдээллийн сангийн горим тогтолцоо бий болгох, мэдээллийн сан бий болгох, цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох судалгааны ажил хийх.

Судалгааны баг дээрх мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд үндэслэн ажлаа төлөвлөж, хэрэгжүүлнэ.

### **1.5 Зөвлөх үйлчилгээний хэрэгжих хугацаа**

Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, цаашид хэрэгжүүлэх бодлого, чиглэл, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон зөвлөмж бүхий тайлан боловсруулах ажлын хүрээнд суурь судалгааг үргэлжлүүлэн зөвлөхийн тайлан, зөвлөмжийг удирдлагуудад танилцуулах ажлуудыг 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдөр дуусвар болохоор төлөвлөв.

Үргэлжлэх хугацаа: Ажлын 37 өдөр

### **1.6 Зөвлөх үйлчилгээний зохион байгуулалт, хамтран ажиллах баг**

Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх явцад төрийн аудитын төв, орон нутгийн байгууллагын холбогдох ажиллагасад шаардлагатай мэдээллээр хангах бөгөөд Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газар, Тамгын газар хамтран үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, зөвлөхтэй хамтран ажиллана.

### **Хоёр. Зөвлөхийн гүйцэтгэх ажил үүрэг**

#### **2.1 Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл**

Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах өгөгдөл, мэдээллийг ажлын даалгаврын 1.6-д заасан баг зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх бүх үе шатанд саадгүй гаргаж өгөх болно.

Зөвлөх шаардлагатай мэдээллийн жагсаалтыг захиалагчид гаргаж өгнө.

#### **2.2 Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэх ажил**

Аудитын зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт, түүний хэрэгжилтийг үнэлэх, мэдээллийн сан бүрдүүлэхэд чиглэсэн дараах ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

##### **2.2.1 Зөвлөгөө өгөх чиглэл**

Зөвлөх нь дараах чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэж, үр дүнг танилцуулна. Үүнд:

1. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны гол үр дүн болох аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт, үр дүнг үнэлэх, дүн шинжилгээ хийх бодлого, тогтолцоо, мэдээллийн санг загварчлах

- 1.1 Өмнөх судалгааны дүн, дүгнэлт, зөвлөмж болон аудитын үйл явцтай холбоотой стандарт, хууль эрхийн актыг судалж, мэдээллийн сан бий болгохтой холбоотой нөхцөл байдал, түүний шалтгаан, үр дагаврыг тодорхойлох

- 1.2 Мэдээллийн сан бий үйл явцыг иж бүрэн зураглах
- 1.3 Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг хэсэг тус бүрээр нь задлан мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлтийг тодорхойлох. Энэ нь эдгээр баримт бичгийг нэгтгэн дүн шинжилгээ хийх, удирдлага болон хэрэглэгчийг мэдээллээр хангах, статистик мэдээ тайлан бэлтгэх боломж нөхцөлийг бүрдүүлэх ёстай.
2. PDF хэлбэрээр байгаа 2018, 2019, 2020 оны өгөгдөл мэдээллийг дээрх загварын дагуу зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын элемэнт тус бүрээр хайлт, шүүлт хийх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх боломжтой байдлаар боловсруулж, мэдээллийн сан бий болгох. Энэ ажлыг PDF файлаар байгаа эх материалыг EXCEL програм руу загварын дагуу шивэх байдлаар гүйцэтгэнэ.

### 2.1 Албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн тоо

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	Дүн
1	Төлбөрийн акт	1 955	1 684	1 820	5 459
2	Албан шаардлага	2 871	2 887	2 879	8 637
3	Зөвлөмж	9 083	7 524	8 304	2 4911
4	Дүн	13 909	12 095	13 003	39 007

3. Аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт, үр дүнг үнэлэх, дүн шинжилгээ хийх цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох судалгааны ажил хийх

Зөвлөхүүд нь дээрх чиглэлийг гол болгох бөгөөд судалгааны явцад бий болсон онцгой нөхцөл байдлыг харгалзан дээрх чиглэлийг захиалагчтай зөвшилцэн өөрчилж болно.

#### 2.2.2 Зөвлөх үйлчилгээний тайлан бэлтгэх

Зөвлөх нь дээрх чиглэлийн дагуу гүйцэтгэсэн ажлын явцад цуглуулсан баримт нотолгоонд үндэслэн зөвлөхийн тайлан бэлтгэнэ. Зөвлөхийн тайлангийн төслийг захиалагчийн саналыг үндэслэн баталгаажуулна. Зөвлөхийн тайлан, зөвлөмжийг албан ёсоор захиалагчид хүлээлгэн өгнө.

#### 2.2.3 Зөвлөх үйлчилгээний үр дүн, зөвлөмжийн талаарх сургалт зохион байгуулах

Зөвлөхүүд ажлын явц, үр дүнгийн талаарх танилцуулга – сургалтын материал бэлтгэж, удирдлагуудад танилцуулна. Шаардлагатай бол аудиторуудад сургалт зохион байгуулна.

#### 2.3 Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчид тавих шаардлага

Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

## **Нууцлал ба аюулгүй байдлыг хангах шалгуур**

Төрийн аудитын байгууллага төрийн ямар ч байгууллагын нууц мэдээлэлтэй өдөр тутам харьцаж, түүнийг тухайн байгууллагын ажиллагсадтай ижил түвшинд нууцлах үүрэг хүлээдэг. Иймд энэ зөвлөх үйлчилгээний мэдээллийн нууцлал ба аюулгүй байдал нэн чухал юм.

Мэдээллийн нууцлалтай холбоотой асуудлыг зөвлөх үйлчилгээний гэрээгээр зохицуулна.

### **Зөвлөхийн мэдлэг чадвар, туршлагын талаарх шаардлага**

Зөвлөх үйлчилгээнд дараах шаардлагыг хангасан этгээд оролцох боломжтой. Үүнд:

- Судалгааны багийн гишүүдэд тавих шаардлага
- Судалгаа, шинжилгээ, арга зүйн чиглэлээр бакалавр, түүний дээш зэрэг эзэмшсэн байх
- Санхүү, эдийн засгийн чиглэлээр бакалавр, түүний дээш зэрэг эзэмшсэн байх
- Мэдээллийн технологийн чиглэлээр бакалавр, түүний дээш зэрэг эзэмшсэн байх
- Өмнө энэ чиглэлээр ижил төстэй судалгааны ажил гүйцэтгэсэн бол давуу тал болно.
- Аудитын ажлын туршлагатай бол давуу тал болох

### **Гурав. Хүлээгдэж буй үр дүн**


Зөвлөхийн үйлчилгээний дуусвар болоход ажлын даалгаврын 2-т заасан ажил үүргийг бүрэн гүйцэтгэж, 1.2-д заасан зорилго биеллээ олсон байх ёстой.

Тухайлбал төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөх үйлчилгээгээр дараах үр дүнг хүлээж байна. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, түүнийг хэрэгжилт, үр дүнг тооцох үйл явцыг иж бүрэн хамарсан мэдээллийн сан бий болгох горим, тогтолцоо бий болгож, үүнийг загварчилсан байх
- Дээрх шаардлагад нийсэн 2018, 2019, 2020 оны 39007 баримт материал загварын дагуу элемент тус бүрээр шүүлт, хайлт, нэгтгэл хийх боломжтой болсон байх
- Төрийн аудитын байгууллагын Харилцагч талуудын оролцооны стратеги, Иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг аудитын тайлагналын дараах үе шатны ажлыг хамтран хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн санг бий болгож, шинжилгээ хийх боломжкоор хангасан байна.
- Зөвлөхийн ажлын явц, үр дүнд суурилан цаашид аудитын үр дүнг стандарт шаардлагын дагуу чанартай үр нөлөөтэй боловсруулах, танилцуулах урт болон дунд хугацаанд баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох

**БОЛОВСРУУЛСАН:**

СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
АРГА ЗҮЙЧ, МЕНЕЖЕР



Ж.БАТСАЙХАН

Аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийн сан бий болгох үйл явцыг загварчлан, өмнөх өгөгдөл мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн сан үүсгэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох судалгааны ажлын зардлын тооцоо

№	Хийгдэх ажил	Ажиллах хүчний зардал			Татвар, шитмэгэл	Хянан удирдлага, зохион байгуулалт, бусад зардал	Бүгд дүн
		Тоо хэмжээ (Хүн/өдөр)	Нэгжийн үнэ	Бүгд дүн			
1	Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны гол үр дүн болох аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт, үр дүнг үнэлэх, дүн шинжилгээ хийх бодлого, тогтолцоо, мэдээллийн санг загварчлах	60	150,000	3,000,000	450,000	300,000	3,750,000
1.1	Холбогдох эрх зүйн актыг судалж, албан шаардлага, төлбөрийн актын төсөл боловсруулах, баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах үйл явцын зураглал гаргах	10	50,000	500,000	75,000	50,000	625,000
1.2	Дээрх зураглалыг үндэслэн мэдээллийн ургаслыг үйл ажиллагаатай нь уялдуулан тодорхойлох	20	50,000	1,000,000	150,000	100,000	1,250,000
1.3	Мэдээлэл хүлээн авах, боловсруулах, үр дүнг нэгтгэж тайлагнах, дүн шинжилгээ хийх маягт боловсруулах	30	50,000	1,500,000	225,000	150,000	1,875,000
2	2018, 2019, 2020 оны өгөгдөл мэдээллийг нэгдсэн системийн шаардлагад нийцүүлэн дээрх маягтаар цахим хэлбэрт шилжүүлэн боловсруулж, мэдээллийн сан бий болгох	180	150,000	9,000,000	1,350,000	900,000	11,250,000
2.1	Албан шаардлага	60	50,000	3,000,000	450,000	300,000	3,750,000
2.2	Төлбөрийн акт	60	50,000	3,000,000	450,000	300,000	3,750,000
2.3	Зөвлөмж	60	50,000	3,000,000	450,000	300,000	3,750,000
3	Аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт, үр дүнг үнэлэх, дүн шинжилгээ хийх цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох судалгааны ажил хийх	100	100,000	5,000,000	750,000	500,000	6,250,000
3.1	Аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг хэрхэн баримтжуулж, баталгаажуулж байгаа байдалд дүн шинжилгээ хийх	50	50,000	2,500,000	375,000	250,000	3,125,000
3.2	Аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, дүн шинжилгээ хийх өнөөгийн нэхцэл байдлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх	50	50,000	2,500,000	375,000	250,000	3,125,000
4	Гүйцэтгэсэн ажлын үр дүнг нэгтгэх, нэгтгэсэн тайлан, зөвлөмж бэлтгэх	20	50,000	1,000,000	150,000	100,000	1,250,000
5	Сургалтын материал боловсруулах	10	150,000	1,500,000		500,000	2,000,000
	Дүн			19,500,000	2,700,000	2,300,000	24,500,000

Тооцоолол хийсэн:

Стратегийн удирдлагын газрын менежер

Ж.Батсайхан